



АНД-ЭНЕРГИ ХК –ийн
удирдлага танаа

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
25-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 дөвхөр, 1502 тоот.
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2022. 02.17 дугаар 21-УБ/03/77-11

танай _____-ны дугаар _____-т

**АУДИТЫН ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ
ТУХАЙ**

Мэжик консалтинг Аудит ХХК-аас томилогдсон аудитын багийн гишүүд АНД-ЭНЕРГИ ХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд завсрын аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд, жилийн эцсийн аудитыг 2022 оны 01 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэж Хараат бус аудиторын тайлан болон Аудитын зөвлөмжийг хүргүүлж байгаа болно.

Бид аудитын ажлыг АОУС, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хууль, Сангийн сайдын тушаал, заавар, журмын заалтуудыг удирдлага болгон явуулахдаа танайхаас ирүүлсэн санхүүгийн тайланд тулгуурласан болно.

Аудитын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай материалыг цаг хугацаанд бэлтгэж өгч, хамтран ажилласан танай компанийн удирдлага, санхүүгийн хэлтсийн ажилчдад талархал дахин илэрхийлье.

Хүндэтгэсэн:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.МӨНХБАЯР



*Аудитын тайланг хүлээн авсан, албан тушаал:
Аудитын тайланг хүлээлгэн өгсөн:
Огноо:*



АУДИТ
БАТАЛГААЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ

АНД-ЭНЕРГИ ХК -ИЙН
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР
ТАСАЛБАР БОЛГОСОН

A large green rectangular area with a faint, dark green silhouette of a city skyline in the background. The skyline includes several buildings of varying heights and a prominent curved structure.

АУДИТОРЫН ТАЙЛАН

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3 - 5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	6
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	7
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	8
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	9
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	10 - 30

АНД-ЭНЕРГИ ХК

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах
Зөвлөл (ТУЗ)-ийн гишүүд:

Д.Мөнхбаяр (ТУЗ-ийн дарга)
Г.Түвшин
Т.Барс
Ш.Сансарсайхан
С. Даваасамбуу
Д.Алтангэрэл
Д.Энхбаяр (Хараат бус)
М.Ганбат (Хараат бус)
М.Сарандаваа (Хараат бус)

Гүйцэтгэх захирал:

Ц.Гүррагчаа

Албан хаяг:

Монгол Улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Уртын гол баг, Баян замын 3-б, “Анд-Энерги”
ХК-ийн байр
Утас: 99361298, 99809336

Харилцагч банк:

Голомт Банк ХХК
Хаан Банк ХХК
Худалдаа Хөгжлийн Банк ХХК

Аудитор:

Мэжик Консалтинг Аудит ХХК
Мэргэшсэн Нягтлан Бодогчид



МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ийн аудиторуудад

АНД-ЭНЕРГИ ХК

Орхон аймаг, Баян-Өндөр сум,

Уртын гол баг Баянзам 3-4.6

Утас: (976) 77711010

Имэйл: info.andenergy@gmail.com

Цахим хуудас: www.andenergy.mn

2022.02.10 № 020/22.

Танай _____-ны № _____-т

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл хүргүүлэх тухай

Анд-Энерги ХК-ийн гүйцэтгэх захирал ажилтай **Цэнд-Аюуш** овогтой **Гүррагчаа**, ерөнхий нягтлан бодогч ажилтай **Чагнаадорж** овогтой **Саранзаяа**, бид ард хавсаргасан 1-ээс 20 дугаар хуудсан дахь Анд-Энерги ХК-ийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх Компанийн санхүүгийн байдал ба уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг шударгаар тайлагнасан гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ХҮНДЭТГЭСЭН



ЦГҮРРАГЧАА

Гүйцэтгэх захирал

2022.02.10.



Ч.САРАНЗАЯА

Ерөнхий нягтлан бодогч

2022.02.10.

00000020



АНД-ЭНЕРГИ ХК-ийн
хувьцаа эзэмшигчид

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
16-р хороо, Амарсанаагийн гудамж, 12-1
Колорадо бизнес төв, 1 давхар, 101 тоот
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2022.02.17 дугаар 21-УБ/03/77
танай _____-ны дугаар _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид АНД-ЭНЕРГИ ХК ('Компани' гэх)-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томсоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЕЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Тасралтгүй байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудлууд

Бидний гүйцэтгэсэн аудитын горим

Татварын тооцооллын үнэн, зөв байдал

Компанийн татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;

Аудитын гол асуудлууд

Бидний гүйцэтгэсэн аудитын горим

Татварын тооцооллын үнэн, зөв байдал (үргэлжлэл)

Монгол улсын татварын бодлого 2020 онд шинэчлэл хийн гол татварын багц хуулиудаа хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.

- Татварын хууль, журам болон практикийн туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Компани ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;
- Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн <http://www.magicgroup.mn/mn/uureg> вэб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх 21-48/03/77 тоот
Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

Бусад асуудал

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ ХХК аудит хийсэн бөгөөд Эерэг дүгнэлт илэрхийлсэн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох АНД-ЭНЕРГИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



С.Мөнхбаяр
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер
Мэжик Консалтинг Аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2022 оны 02 дүгээр сарын 17

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	13,288.5	25,659.0
Дансны авлага	5	299,802.7	197,477.2
Татвар, НДШ-ийн авлага	6	488.3	11,961.9
Бусад авлага	7	2,481.5	32,655.4
Бараа материал	8	349,216.8	619,299.3
Урьдчилж төлсөн төлбөр	9	214,732.7	
Эргэлтийн хөрөнгийн дүн		880,010.5	887,052.8
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	1,667,908.7	1,769,503.0
Биет бус хөрөнгө	11	67,220.3	62,988.0
Биологийн хөрөнгө	12	6,500.0	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,741,629.0	1,832,491.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2,621,639.5	2,719,543.8
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дансны өглөг	13	24,070.1	17,552.8
Татварын өглөг	14	19,185.4	46,084.5
НДШ-ийн өглөг	15	26,249.5	16,640.9
Богино хугацаат зээл	17	51,247.5	489,424.9
Хүүний өглөг	17	434.0	
Урьдчилж олсон орлого	16	22,486.5	6,985.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн		143,673.0	579,688.1
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	17	406,214.0	47,450.5
Урт хугацаат өр төлбөрийн дүн		406,214.0	47,450.5
Нийт өр төлбөрийн дүн		549,887.0	627,138.6
Өөрийн хөрөнгө			
Хувьцаат капитал	18	78,070.8	78,070.8
Нэмж төлөгдсөн капитал	18	1,470,540.8	1,470,540.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	264,224.4	264,224.4
Хуримтлагдсан ашиг	20	258,916.5	279,569.2
Нийт цэвэр хөрөнгийн дүн		2,071,752.5	2,092,405.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,621,639.5	2,719,543.8

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АНД-ЭНЕРГИ ХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Борлуулалтын орлого /цэвэр/	21	2,030,853.7	2,205,820.7
Борлуулалтын өртөг	22	1,266,555.7	1,312,416.5
Нийт ашиг		764,298.0	893,404.2
Хүүний орлого			310.9
Бусад орлого	23	16,709.5	699.8
Борлуулалт, маркетингийн зардал	24	-121,180.3	-118,221.2
Ерөнхий удирдлагын зардал	25	-541,032.8	-620,070.5
Санхүүгийн зардал	26	-78,359.3	-99,372.7
Бусад зардал	27	-24,813.0	-31,697.0
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/		0.7	3.9
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/		-198.6	
Татвар төлөхийн өмнөх ашиг		15,424.2	25,057.6
Орлогын татварын зардал		-1,542.4	-502.4
Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг		13,881.8	24,555.2

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АНД-ЭНЕРГИ ХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

<i>Үзүүлэлт (мян.төг)</i>	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020-01-01-ний үлдэгдэл	78,070.8	1,470,540.8	72,573.7	364,587.2	1,985,772.5
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга				-15,888.5	15,888.5
Залруулсан үлдэгдэл	78,070.8	1,470,540.8	72,573.7	348,698.7	1,969,884.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	24,555.2	24,555.2
Зарласан ногдол ашиг	-	-	-	-93,684.7	-93,684.7
Дахин үнэлгээний нэмэгдэл			191,650.7	-	191,650.7
2020-12-31-ний үлдэгдэл	78,070.8	1,470,540.8	264,224.4	279,569.2	2,092,405.2
НББ-ийн өөрчлөлт, алдааны залруулга				-34,534.5	-34,534.5
Залруулсан үлдэгдэл	78,070.8	1,470,540.8	264,224.4	245,034.7	2,057,870.7
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				13,881.8	13,881.8
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдэл					
2021-12- 31-ний үлдэгдэл	78,070.8	1,470,540.8	264,224.4	258,916.5	2,071,752.5

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АНД-ЭНЕРГИ ХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2021 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

	2021	2020
	мян.төг	мян.төг
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	2,189,615.9	2,469,820.5
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,609,701.4	2,113,942.7
Бусад мөнгөн орлого	579,914.5	355,877.8
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	2,051,512.3	2,432,051.3
Ажиллагчдад төлсөн	247,777.1	333,806.8
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	82,122.1	58,726.3
Бараа материал худалдан авахад төлсөн	1,063,032.0	1,557,529.6
Ашиглалтын зардалд төлсөн	8,818.4	6,386.6
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,442.1	2,226.4
Хүүний төлбөрт төлсөн	77,925.2	99,372.7
Татварын байгууллагад төлсөн	210,782.0	192,480.7
Даатгалын төлбөрт төлсөн	1,256.9	-
Бусад мөнгөн зарлага	327,356.5	181,522.2
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	138,103.6	37,769.2
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	7,000.0	310.9
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,000.0	
Бусдад олгосон зээл мөнгөн урь-ны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүгийн орлого		310.9
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	76,900.4	91,326.0
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,285.0	59,007.8
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,232.2	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	58,383.2	32,318.2
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-69,900.4	-91,015.1
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	722,870.0	555,476.9
Зээл авсан, өрийн үнэт цаас гар-аас хүлээн авсан	722,870.0	555,476.9
<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	803,443.7	523,094.7
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	803,443.7	438,778.3
Төлсөн ногдол ашиг		84,316.4
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-80,573.7	32,382.2
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-12,370.5	-20,863.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,659.0	46,522.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,288.5	25,659.0

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Анд-Энерги ХК нь 2011 оны 05 дугаар сарын 16-нд үүсгэн байгуулагчдын 01 дугаар тогтоолоор байгуулагдан, Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, 2010001005 хувийн хэргийн дугаартай 000150537 дугаар улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна. Компанийн регистрийн дугаар 4385772.

Компанийн эрхэм зорилго нь: “Мэдлэгт суурилсан үнэ цэнэтэй бүтээлээр дэлхий ертөнцийг гэрэлтүүлнэ”. Дараах чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- 2740-LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл
- 4610-Гадаад худалдаа
- 3314-Цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
- 3320-Үйлдвэрлэлийн автоматжуулалт

2018 оны 1 дугаар сарын 15-ны өдөр Хувьцаат компанийн дүрмийг шинэчлэн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Компанийн гаргасан нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 78,080,758 ширхэг энгийн хувьцааг Монгол Улсын иргэн Г.Түвшин, Т.Барс, Ц.Гүррагчаа, Д.Мөнхбаяр нар тус бүр 16.5% хувь, 34%-ийг бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Нийт хувьцаа эзэмшигчид 427.

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2020 оны 10 дугаар сар 28-ны өдрийн А/190 дугаар тушаалаар улсын бүртгэлийн 40-0022638 дугаар барааны тэмдэгт хамаарах Ангилал 9, 10, 11-ын барааны тэмдэгтийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгосон байна.

Эрчим хүчний яамны 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1149/21 дугаар бүхий 0.4 – 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай сунгасан байна.

Тус компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурал. Хувьцаа Эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал удирдана.

Тус компани нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 35 ажиллагсадтай байна.

Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг нь: Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян замын 3-6, “Анд-Энерги” ХК-ийн байр

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа Анд-Энерги ХК-аас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд Олон улсын нягтлан бодох бүртгэл болон стандартын зөвлөлөөс гаргасан Санхүү тайлагналын олон улсын стандартуудын (“СТОУС”) дагуу бэлтгэгдсэн болно.

Компанийн санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан болно.

2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан.

Санхүүгийн тайланг бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцоллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд гарсан өөрчлөлтийг өөрчлөлт гарч буй тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тусгадаг.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

а. Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
 - Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
 - Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
 - Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
- Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.

Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

б. Бэлэн мөнгө болон банкин дахь данс

Бэлэн мөнгө болон банкин дахь дансанд банканд байршуулсан мөнгө орно.

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, дээр тодорхойлсноор бэлэн мөнгө болон банкин дахь харилцах, хадгаламж дахь бэлэн мөнгө болон богино хугацаатай хадгаламжийг банкны овердрафтын үлдэгдлийг багтаахгүйгээр оруулсан.

в. Санхүүгийн хэрэгсэл

Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өрийг санхүүгийн байдлын тайланд тусгадаг. Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

г. Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн хэрэгслийг дараах байдлаар ангилдаг. Үүнд: бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгсэл, гэрээний хугацаа дуустал эзэмших хэрэгсэл, арилжаалах боломжтой хэрэгсэл ба зээл ба авлага болно. Энэхүү ангилал нь тухайн санхүүгийн хөрөнгийн мөн чанар болон тэдгээрийг ямар зориулалтаар эзэмшиж байгаагаас хамаарах ба анх бүртгэхдээ ангиллыг тогтоодог. Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг. Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Компанийн санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагаас бүрдэж байна.

- Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй бөгөөд тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөрийн хуваарьтай үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Зээл ба авлага (үүнд дансны ба бусад авлагууд, касс болон харилцах, хадгаламжийн дахь мөнгөн хөрөнгө)-ыг бодит хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг нь хассан дүнгээр хэмжиж илэрхийлдэг. Хүүгийн орлогыг бодит хүүгийн аргаар тооцож бүртгэдэг боловч хүүгийн орлого нь материаллаг бус богино хугацааны авлагад нэрлэсэн хүүгийн хувиар орлогыг бүртгэдэг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

г. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

- Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл санхүүгийн хөрөнгө шилжүүлсэн, хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг бусдад шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хэрвээ Компани нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Компанид үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээрээ үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ.

д. Бодит үнэ цэнээрх хэмжилт

Санхүүгийн тайланд хэд хэдэн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжиж тодруулахыг шаарддаг. Компанийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэний хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэжээгээр хэргэлдэг. Бодит үнэ цэний хэрэгжилтэд хэрэглэгдэх өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түшинд ангилдаг.

Түвшин1: Идэвхтэй зах зээл дэх ижил төстэй зүйлсийн жишиг үнэ.

Түвшин2: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд ба шууд бус өгөгдөл

Түвшин3: Үл ажиглагдахуйц өгөгдөл (зах зээлийн бус мэдээлэл) Өгөгдсөн зүйлсийн бодит үнэ цэний хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх хэрэглэгдсэн өгөгдлийн хамгийн бага түвшинд үндэслэн зүйлсийг дээрх түвшинд ангилдаг.

ё. Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр борлогдох үнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртөгт бараа материалыг худалдан авах, үйлдвэрлэх өртөг буюу хувиргалтын зардлууд болон барааг одоогийн шинж байдал болон байрлалд авчрах хүртэл гарсан бүх зардлаас бүрддэг ба сарын жигнэсэн дунджийн аргыг ашиглан өртгийг тодорхойлдог.

Үйлдвэрлэсэн бараа материал болон дуусаагүй үйлдвэрлэлийн өртөгт хэвийн үйл ажиллагааны хүчин чадлаар тооцсон үйлдвэрлэлийн нэмэлт зардлын зохих хэсгийг оруулдаг.

Цэвэр борлогдох үнэ гэдэг нь хэвийн бизнесийн үед бараа материалын худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон борлуулахад гарахаар тооцоолсон зардлыг хассан дүн юм.

3. Урьдчилж төлсөн төлбөрүүд

Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлуудыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд хөрөнгө хэсэгт бүртгэгдэх ба төлсөн бэлэн мөнгөний дүнгээр хэмжигдэнэ. Үүний дараа үйл ажиллагаанд хэрэглэгдсэн буюу хугацаа нь дуусахад орлогын тайланд тусгагддаг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

и. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Хөрөнгийн ашиглалт дуусаж эсвэл өртөг болон холбогдох хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт нь данснаас хасагдахад үүсэх олз болон гарз нь ашиг алдагдалд кредитлэгдэнэ.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан бодит үнэ цэнээр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар, дараах ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ. Үүнд:

Ангилал	Жил
Барилга байгууламж	40
Тоног төхөөрөмж	10
Тавилга эд хогшил	10
Компьютер, түүнтэй адилтгах хөрөнгө	2

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтэй холбогдон үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг багалгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

й. Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнес нэгдлийн үед авсан биет бус хөрөнгийг авсан өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорөгдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

й. Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Дотооддоо хөгжүүлсэн биет бус хөрөнгийн хувьд хөгжүүлэлтийн зардлаас бусад зардал өртгийг нэмэгдүүлэхгүй. Үүний оронд холбогдох зардлуудыг зардал гарсан тайлант хугацаанд олз, гарзаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Компанийн эзэмшиж байгаа бүх биет бус хөрөнгүүд нь тодорхой ашиглалтын хугацаатай.

Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн тухай бүрд үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Компанийн биет бус хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн программ хангамж бөгөөд шулуун шугамын аргыг ашиглан гурван (3) жил, Тусгай зөвшөөрлийг ашиглалтын хугацаанд хорогдуулна.

к. Өөрийн хөрөнгө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөнөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

л. Борлуулалтын орлого

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Компанид орох нь тодорхой болсон болон найдвартайгаар хэмжих боломжтой болсон хэр хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээс хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын татвар эсвэл хураамжийг хассан дүнгээр хүлээн зөвшөөрнө.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

м. Зардал

Зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад эдийн засгийн өгөөжийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардлыг гарсан үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

н. Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Удирдлага НББ-ийг хэрхэн хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

Хойшлогдсон албан татвар

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд “Балансын арга”-ыг ашиглан хойшлогдсон албан татварыг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвилийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед,

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

АНД-ЭНЕРГИ ХК
САИХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

н. Татвар (үргэлжлэл)

Хойшлогдсон албан татвар (үргэлжлэл)

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;
- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна.

Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

н. Татвар (үргэлжлэл)

Нэмэгдсэн өртгийн албан татвар (үргэлжлэл)

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

о. Гадаад валютын хөрвүүлэлт

Компанийн санхүүгийн тайланг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээг хүлээн зөвшөөрөх шаардлага хангасан өдрийн ханшаар мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Бүх зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ.

Түүхэн өртгөөр хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг тэдгээрийн анхны гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээр хэмжигдэх, мөнгөн зүйлсийн хөрвүүлгээс үүссэн олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар хүлээн зөвшөөрнө. (өөрөөр хэлбэл бодит үнэ цэнийн зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн зүйлийн ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг мөн адил бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланд бүртгэнэ.)

ө. Холбоотой талуудын гүйлгээ

Холбоотой тал гэдэг нь Компанитай холбоотой хувь хүн эсвэл байгууллага байна.

(а) Хувь хүн эсвэл тухайн хүний гэр бүлийн ойрын гишүүн доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (i) Компанийн хяналт болон хамтын хяналт байдаг бол;
- (ii) Компанид томоохон нөлөөлөл байдаг бол;
- (iii) Компанийн гол удирдах ажилтан эсвэл Компанийн толгой компанийн гишүүн бол.

(б) Аж ахуйн нэгж байгууллага нь доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (i) Компани болон аж ахуйн нэгж нь нэг группийн гишүүд бол (өөрөөр хэлбэл толгой компани, охин компани ба зэргэлдээ охин компани бүр нь хоорондоо холбоотой юм);
- (ii) Компани болон аж ахуйн нэгж нь нэг группийн гишүүд бол (өөрөөр хэлбэл толгой компани, охин компани ба зэргэлдээ охин компани бүр нь хоорондоо холбоотой юм);

**АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

ө. Холбоотой талуудын гүйлгээ (үргэлжлэл)

- (iii) нэг байгууллага нь нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, өөр байгууллага нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);
- (iv) хоёр компани хоёулаа нэг гуравдагч талын хамтын үйлдвэр бол;
- (v) нэг тал нь нөгөө талын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, нөгөө тал нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);
- (vi) байгууллага нь Компанийн эсвэл Компанитай холбоотой талын ажилчдын тэтгэмжтэй холбоотой ажлаас гарсны дараах тэтгэмжийн хөтөлбөр бол. Хэрвээ Компани өөрөө тэр хөтөлбөр бол, ажил олгогчийн спонсор нь мөн Компанитай холбоотой тал болно;
- (vii) (а)-д заасан хувь хүнд байгууллагын хяналт эсвэл хамтын хяналт байдаг бол;
- (viii) (а)(i)-д заасан хувь хүнд байгууллагын томоохон нөлөө байх эсвэл тухайн хүн нь компанийн гол удирдах ажилтан бол (эсвэл толгой компанийн);
- (ix) Компанид эсвэл Компанийн толгой компанид гол удирдах ажилтнаар хангах үйлчилгээ үзүүлдэг байгууллага эсвэл группийн ямарваа гишүүн бол.

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАСРАЛТГҮЙ ЗАРЧИМ

Компани 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 258,916.5 (2020: 279,569.2) мянган төгрөгийн хуримтлагдсан ашигтай, 143,673.0 (2020: 579,688.1) мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй, 880,010.5 (2020: 887,052.8) мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй ажилласан байна. Компанийн хувьд тасралтгүй үйл ажиллагаа явуулах нь ирээдүйн ашгийг нэмэгдүүлж ажиллах чадвар болон ирээдүйн эерэг мөнгөн урсгалаас хамаарна. Тайлант өдрөөр Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл ажиглагдаагүй тул Компанийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвартай гэж үзэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэсэн болно.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

4. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	<u>2021</u>	<u>2020</u>
Касс дахь бэлэн мөнгө	1,554.1	1,328.7
Харилцах дахь бэлэн мөнгө	11,734.4	24,330.3
	<u>13,288.5</u>	<u>25,659.0</u>

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь монгол төгрөг, Худалдаа Хөгжлийн Банк, Хаан банк, Голомт банкны харилцах дахь монгол төгрөг, гадаад валютаас бүрдэж байна.

5. ДАНСНЫ АВЛАГА

	<u>2021</u>	<u>2020</u>
Борлуулалтын авлага	299,802.7	197,477.2
Нийт дансны авлага	<u>299,802.7</u>	<u>197,477.2</u>

2021-12-31-ний байдлаар Дансны авлага 102,325.5 мянган төгрөгөөр буюу 52 хувиар өссөн. Дансны авлага нь 100 хувь Борлуулалтын авлага данснаас бүрдсэн байна. Нийт хөрөнгийн 11.44 хувийг Дансны авлага эзэлж байна.

6. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

	<u>2021</u>	<u>2020</u>
Орлогын татварын авлага	-	11,961.9
Бусад татварын тооцоо	488.3	-
	<u>488.3</u>	<u>11,961.9</u>

7. БУСАД АВЛАГА

	<u>2021</u>	<u>2020</u>
Хувь хүнээс авах авлага	2,481.5	29,562.1
Бусад авлага	-	3,093.3
	<u>2,481.5</u>	<u>32,655.4</u>

2021-12-31-ний байдлаар Бусад авлага 30,173.8 мянган төгрөгөөр буюу 13.16 дахин буурсан. Бусад авлага нь 100 хувь Хувь хүнээс авах авлага гэсэн данснаас бүрдсэн байна.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

8. БАРАА МАТЕРИАЛ

	<u>2021</u>	<u>2020</u>
Түүхий эд материал	126,313.8	301,428.5
Дуусаагүй үйлдвэрлэл	11,928.9	120,660.5
Бэлэн бүтээгдэхүүн	138,875.6	137,814.4
Хангамжийн материал	72,098.5	59,395.9
	<u>349,216.8</u>	<u>619,299.3</u>

2021-12-31-ний байдлаар Бараа материал 270,082.6 мянган төгрөгөөр буюу -44 хувиар буурсан. Бараа материалын хамгийн их буюу 39.77 хувийг Бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна. Нийт хөрөнгийн 13.32 хувийг Бараа материал эзэлж байна.

9. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР

	<u>2021</u>	<u>2020</u>
Урьдчилж төлсөн тооцоо	214,732.7	-
	<u>214,732.7</u>	<u>-</u>

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	<u>2021</u>	<u>2020</u>
Барилга байгууламж	1,478,225.9	1,462,512.3
Хуримтлагдсан элэгдэл. Барилга	-135,006.9	-88,671.3
Машин, тоног төхөөрөмж	261,290.3	260,035.1
Хуримтлагдсан элэгдэл. МТТ	-92,751.8	-51,482.7
Тээврийн хэрэгсэл	83,272.1	98,272.1
Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	-30,879.5	-29,687.0
Тавилга эд хогшил	132,745.3	130,654.3
Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	-38,463.6	-24,060.9
Компьютер, бусад хэрэгсэл	41,306.4	36,626.6
Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	-31,829.5	-24,695.5
	<u>1,667,908.7</u>	<u>1,769,503.0</u>

2021-12-31-ний байдлаар үндсэн хөрөнгийн дүн 95,094.2 мянган төгрөгөөр буюу -5 хувиар буурсан. Үндсэн хөрөнгийн хамгийн их буюу 73.79 хувийг Барилга байгууламж эзэлж байна. Оны эцсийн байдлаар нийт үндсэн хөрөнгийн анхны өртөг 1,996,840.0 мянган төгрөг, хуримтлагдсан элэгдэл -332,259.2 мянган төгрөг, үлдэгдэл өртөг 1,667,908.7 төгрөг. 16.64 хувь нь элэгдсэн үзүүлэлттэй байна. Үндсэн хөрөнгө нь Нийт хөрөнгийн 63.62 хувийг эзэлж байна.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	<u>2021</u>	<u>2020</u>
Биет бус хөрөнгө	70,548.2	66,316.0
Хуримтлагдсан элэгдэл, биет бус хөрөнгө	-3,327.9	-3,328.0
	<u>67,220.3</u>	<u>62,988.0</u>

Нийт хөрөнгийн 2.56 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. 2021-12-31-ний байдлаар Биет бус хөрөнгө-Цэврээр 4,232.2 мянган төгрөгөөр буюу 7 хувиар өссөн.

12. БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

	<u>2021</u>	<u>2020</u>
Биологийн хөрөнгө	6,500.0	-
	<u>6,500.0</u>	<u>-</u>

13. ДАНСНЫ ӨГЛӨГ

	<u>2021</u>	<u>2020</u>
Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	24,070.1	17,552.8
	<u>24,070.1</u>	<u>17,552.8</u>

14. ТАТВАРЫН ӨГЛӨГ

	<u>2021</u>	<u>2020</u>
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	10,944.4	46,084.5
Орлогын татварын тооцоо	988.5	
Хувь хүний орлогын албан татварын өглөг	7,702.5	19,640.9
	<u>19,185.4</u>	<u>65,725.4</u>

2021-12-31-ний байдлаар Татварын өр 46,540.0 мянган төгрөгөөр буюу 3.43 дахин буурсан. Татварын өглөгийн хамгийн их буюу 57.31 хувийг НӨАТ-ын тооцоо эзэлж байна. Нийт өр төлбөрийн 3.49 хувийг татварын өглөг эзэлж байна.

15. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

	<u>2021</u>	<u>2020</u>
НДШ-ийн өглөг	26,249.5	-
	<u>26,249.5</u>	<u>-</u>

16. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

	<u>2021</u>	<u>2020</u>
Урьдчилж орсон орлого	22,486.5	6,985.0
	<u>22,486.5</u>	<u>6,985.0</u>

17. ЗЭЭЛ

Богино хугацаат

	<u>2021</u>	<u>2020</u>
Богино хугацаат зээл	51,247.5	489,424.9
	<u>51,247.5</u>	<u>489,424.9</u>

**АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

Урт хугацаат

	<u>2021</u>	<u>2020</u>
Банкны зээл	406,214.0	47,450.5
	<u>406,214.0</u>	<u>47,450.5</u>

Худалдаа хөгжлийн банк

Худалдаа хөгжлийн банкнаас 2019.05.22-ны өдөр эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 22.2 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай 100,000.0 мянган төгрөгийн зээл авсан ба 2019.11.08-нд зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, нэмэлтээр 100,000.0 төгрөгийн зээлийг нэмж хугацааг 12 сар болгон өөрчилсөн, 2020.09.17-нд дахин 200,000.0 мянган төгрөгийн зээл авч, 2021.05.14-нд зээлийн үлдэгдэл 197,800.0 мянган төгрөгийг жилийн 3 хувийн хүүтэй 36 сарын хугацаатай болгон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Мөн тус өдрөөр ажлын байрыг хадгалах, бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, банкнаас ижил зориулалтаар авсан зээлийн хүүг дахин санхүүжүүлэх зорилгоор 3 хувийн хүүтэй 36 сарын хугацаатай 302,200.0 мянган төгрөгийн зээл авсан байна.

Уг зээлийн барьцаанд үйлдвэрлэлийн зориулалттай барилга болон газар эзэмших эрхийг тавьсан байна.

Хаан банк

Хаан банкнаас 2019 оны 3 сарын 06-ны түүхий эд материал худалдан авах эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зориулалтаар жилийн 15 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай 100,000.0 мянган төгрөгийн зээл авсан. 2021.01.01-нээрх зээлийн үлдэгдэл 47,450.0 мянган төгрөг нь төлөгдөж үлдэгдэлгүй болсон байна.

2021-12-31-ний байдлаар Урт хугацаат өглөг 358,763.5 мянган төгрөгөөр буюу 8.56 дахин өссөн. Нийт өр төлбөрийн 73.87 хувийг Урт хугацаат зээл эзэлж байна.

Хүүний өглөг

	<u>2021</u>	<u>2020</u>
Хүүний өглөг	434.0	-
	<u>434.0</u>	<u>-</u>

18. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	<u>2021</u>	<u>2020</u>
Хувийн өмч	78,070.8	78,070.8
Нэмж төлөгдсөн капитал	1,470,540.8	1,470,540.8
	<u>1,548,611.6</u>	<u>1,548,611.6</u>

Компанийн хувьцаат капитал 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 78,070,758 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байсан.

Компанийн нийт зарласан хувьцааны тоо 100,000,000 ширхэг

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

Компанийн томоохон хувьцаа эзэмшигчдийн хүснэгтээр харуулбал:

д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Иргэншил	Эзэмших хувь
1	Т.Барс	Монгол Улс	16.5 хувь
2	Ц.Гүррагчаа	Монгол Улс	16.5 хувь
3	Г.Түвшин	Монгол Улс	16.5 хувь
4	Д.Мөнхбаяр	Монгол Улс	16.5 хувь
5	Бусад хувьцаа эзэмшигчид	Монгол Улс	34.0 хувь

19. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

	<u>2021</u>	<u>2020</u>
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	264,224.4	264,224.4
	<u>264,224.4</u>	<u>264,224.4</u>

20. ХУРИМТЛАГДСАН АШИГ

	<u>2021</u>	<u>2020</u>
Тайлант үеийн ашиг	13,881.8	-
Өмнөх үеийн ашиг	245,034.7	279,569.2
	<u>258,916.5</u>	<u>279,569.2</u>

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 21/12 дугаар тогтоолоор 22,873.0 мянган төгрөгийн авлага, татварын хөнгөлөлтөд хамрагдаж чадаагүй 11,661.4 мянган төгрөг, нийт 34,534.4 мянган төгрөгөөр НББОУС 8-ын дагуу өмнөх тайлант хугацааны алдааг дахин залруулсан байна.

21. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	<u>2021</u>	<u>2020</u>
Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	2,030,853.7	2,205,820.7
	<u>2,030,853.7</u>	<u>2,205,820.7</u>

Компанийн үндсэн үйл ажиллагааны орлого нь лед гэрлийн борлуулалт, автоматжуулалтын ажил, гэрэлтүүлгийн ажил, бусад засвар үйлчилгээний орлогоос бүрдэж байна.

Ажил үйлчилгээг гүйцэтгэж томоохон үнийн дүн бүхий “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Эм Ти Ай Эс ХХК-тай хийсэн гэрээт ажлын орлого байна.

2021-12-31-ний байдлаар Борлуулалтын орлого 174,967.1 мянган төгрөгөөр буюу 8 хувиар буурсан.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

22. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

	<u>2021</u>	<u>2020</u>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,266,555.7	1,312,416.5
	1,266,555.7	1,312,416.5

Компани нь үйлдвэрлэлтэй хамааралтай зардлууд болох үйлдвэрийн ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, түүхий эд материалын зардал болон бусад үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөгт хуваарилдаг.

2021-12-31-ний байдлаар Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 45,860.8 мянган төгрөгөөр буюу 3 хувиар буурсан. 2020 онд Нийт борлуулалтын 59.50 хувь, 2021 оны байдлаар 62.37 хувь нь Борлуулсан бүтээгдэхүүний өртөг байна. Өөрчлөлт 2.87 хувь

23. БУСАД ОРЛОГО

	<u>2021</u>	<u>2020</u>
Үйл ажиллагааны бус орлого	5,626.7	699.8
Засгийн газрын дэмжлэг	11,082.8	
	16,709.5	699.8

24. БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

	<u>2021</u>	<u>2020</u>
Ажиллагчдын цалингийн зардал	72,756.2	91,502.0
ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	9,543.4	5,282.0
Албан татвар, төлбөр, хураамж		11,108.0
Түрээсийн зардал	6,985.0	4,855.0
Тээврийн зардал	1,350.1	2,273.0
Зар сурталчилгааны зардал	20,798.0	2,813.0
Бусад зардал	9,747.6	388.0
	121,180.3	118,221.0

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

25. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2021	2020
Ажиллагчдын цалингийн зардал	271,333.0	381,165.7
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	55,635.2	22,002.8
Албан татвар, төлбөр, хураамж	1,357.4	12,290.7
Томилолтын зардал	600.0	2,656.2
Бичиг хэргийн зардал	4,275.4	2,793.7
Шуудан холбооны зардал	3,042.2	3,582.5
Мэргэжлийн үйлчилгээний зардал	8,530.0	21,616.8
Сургалтын зардал	3,446.0	4,141.0
Даатгалын зардал	865.2	
Ашиглалтын зардал	7,613.1	21,099.2
Засварын зардал	13,870.9	11,835.2
Элэгдэл, хорогдлын зардал	118,771.7	84,581.6
Түрээсийн зардал		18,971.5
Харуул хамгаалалтын зардал	2,795.6	1,415.9
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2,637.0	
Тээврийн зардал	1,115.1	9,594.0
Шатахууны зардал	12,342.2	
Зар сурталчилгааны зардал		21,399.3
Газрын төлбөр	377.8	924.4
Бусад	32,425.1	
Нийт дүн	541,032.8	620,070.5

26. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2021	2020
Хүүгийн зардал	78,359.3	99,372.7
Нийт дүн	78,359.3	99,372.7

27. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

	2021	2020
Хандивын зардал	4,622.3	7,701.0
Найдваргүй авлагын зардал	10,068.8	
Үйл ажиллагааны бус зардал	10,121.9	23,996.0
Нийт дүн	24,813.0	31,697.0

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 21/11 дугаар тогтоолоор 10,068.8 мянган төгрөгийн авлагыг найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн байна.

28. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Хяналт хэрэгжүүлдэг талууд болон түүнтэй шууд хамааралтай талуудыг холбоотой тал гэж үзнэ. Холбоотой талуудыг тодорхойлохдоо компаниас гаргаж өгсөн болон нийтэд ил тод байгаа мэдээлэлд суурилсан учраас тодруулагдаагүй бусад холбоотой талууд, ажил гүйлгээ байж болзошгүй.

Компанийн холбоотой талууд болон тэдгээрийн харилцан хамаарлыг харуулбал:

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

Холбоотой талууд	Харилцан хамаарал
Ц.Гүррагчаа	Гүйцэтгэх захирал, Компанийн 16.5 хувийг эзэмшигч
Т.Барс	Үйлдвэрлэл, ХАБЭА хариуцсан захирал, Компанийн 16.5 хувийг эзэмшигч
Д.Мөнхбаяр	Компанийн ТУЗ-ийн дарга, Компанийн 16.5 хувийг эзэмшигч
Г.Түвшин	Компанийн 16.5 хувийг эзэмшигч
Ш.Сансарсайхан	Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаагийн гэр бүлийн гишүүн, Тэгш таван сайхан ХХК-ийн захирал
Д.Алтангэрэл	ТУЗ-ын ердийн гишүүн, “АЦХ” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Холбоотой талууд 2021.12.31-нээр	Хамаарал	Зээл /мян.төг/	Авлага /мян.төг/
Ц.Гүррагчаа	Компанийн хувьцааны 16.5%-г эзэмшигч	-	500.0

29. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР БА САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны ба бусад авлага, дансны ба бусад өглөг бүрддэг. Компани нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэг. Компани арилжаалах болон санхүүгийн хамгаалалт хийх зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэггүй болно. Компанийн санхүүгийн хэрэгслээс үүсэлтэй үндсэн эрсдэлүүдийг гадаад валютын эрсдэл, зээлийн эрсдэл гэж ангилж болно.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг хураангуйлан өгүүлбэл:

29.1. Зээлийн эрсдэлийн удирдлага

Компанийн харилцагчид зээлийн нөхцөлөө худалдан авалт хийгээд түүнийгээ төлж чадахгүй болсноор Компанид санхүүгийн хохирол учрах зээлийн эрсдэлийг үүсгэдэг. Одоогийн байдлаар зах зээлд хараат бус үнэлгээний байгууллага байхгүй байна. Иймээс Компанийн зүгээс баримталдаг зээлийн борлуулалтын бодлогын дагуу удаан хугацаанд харилцсан, найдвартай харилцагчдад зээлийн лимит олгож баталдаг. Жил бүр худалдан авагчтай хийсэн борлуулалтын гэрээг шинэчилж гэрээний хэрэгжилтийг байнга хянадаг. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн ба зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь санхүүгийн тайлан дахь санхүүгийн хөрөнгө бүрийн дансны үнээр хязгаарлагддаг.

	2021	2020
Банкин дахь харилцах	11,734.4	24,330.3
Дансны авлага	299,802.7	197,477.2
Бусад авлага	2,481.6	32,655.4
Урьдчилж төлсөн төлбөр	214,732.7	
	528,751.4	254,462.9

Компани гуравдагч талд санхүүгийн баталгаа гаргаагүй.

Компани тайлант хугацааны эцсээрх дансны ба бусад авлагад барьцаа аваагүй.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

29. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР БА САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
(ҮРГЭЛЖЛЭЛ)

29.2. Гадаад валютын эрсдэлийн удирдлага

Гадаад валютын сөрөг өөрчлөлтөөс үүсэж болох алдагдал, гарзыг илэрхийлнэ. Компани үндсэн түүхий эдийг импортоор оруулж ирдэг учир гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг. Эрдэлд өртөж болох гол валют нь БНХАУ-ын юань байна. Гадаад валютын хэт хэлбэлзэл нь тус компанийн санхүүгийн байдал, мөнгөн урсгалд нөлөөлөх магадлалтай.

Тайлант үед гадаад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг түүхэн ханшаар хөрвүүлдэг. Гадаад валютаарх бүх ажил гүйлгээг хөрвүүлэхтэй холбоотой үүссэн бүх олз, гарз орлого үр дүнгийн тайланд толилуулагдана.

Үзүүлэлт	Хаалтын ханш	Өсөлт, бууралт	Өсөлт бууралтын хувь
2019.13.31	2,733.52	90.60	3.31%
2020.12.31	2,849.51	115.99	4.07%
2021.12.31	2,848.80	-0.71	-0.02%

Компани тайлант үед гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн болон мөнгөн бус зүйлс /хөрөнгө, ер төлбөрийг/ Монгол банкны албан ханшаар хөрвүүлж, тэгшитгэдэг байна.

29.3. Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм. Компани нь одоогийн байдлаар Худалдаа хөгжлийн банкнаас зээлтэй бөгөөд зээлийн хүү тогтмол шинж чанарыг агуулж байна. Хүүг үндсэн зээлийн үлдэгдлээс хүү бодох зарчмаар бодож, графикийн дагуу төлөлтийг сар тутамд хийдэг тул хүүгийн түвшний эрсдэл дунд зэрэг байна.

29.4. Үйл ажиллагааны эрсдэл

Удирдлага болон хувь хүний санаатай болон санамсаргүй алдаа, үйлдвэрлэлийн доголдлын улмаас компани нэр хүндээ алдах, борлуулалтын буцаалт үүсэх, борлуулалтын гэрээ цуцлагдах, хуулийн хариуцлага хүлээх зэргээр санхүүгийн эрсдэл үүсэхийг үйл ажиллагааны эрсдэл гэнэ. Компанийн үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн гүйцэд арилгах, удирдах боломжгүй боловч гүйцэтгэх удирдлагуудын ээлжит болон ээлжит бус хурлаар асуудлыг урьдчилан төлөвлөж хэлэлцэх, хууль, дүрэм журмын өөрчлөлтөөс үүсэж болох эрсдэл, эрсдэлийг бууруулж болох зүйлсийг судлах, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах зэргээр хяналт хэрэгжүүлж, эрсдэлийг удирдаж байна.

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

29. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР БА САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
(ҮРГЭЛЖЛЭЛ)

29.5. Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл бөгөөд мөнгөн урсгалыг удирдах чадвараас ихээхэн хамаарна. Компанийн бодлого өр төлбөр төлөх хугацаа болоход хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд компани нь хүлээгдэж буй шаардлагыг биелүүлэхийн тулд тогтмол бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байх явдал юм. Компани тухайн жилийн төсвийг мөнгөн урсгалын хэрэгцээ шаардлагыг үнэлсний үндсэн дээр бэлтгэнэ. Компанийн удирдлага нь өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа, өрийн харьцааг зохистой байлгахад анхаарал тавьж байгаа бөгөөд өөрийн хөрөнгө нь хувьцаат капитал ба хуримтлагдсан ашгаас бүрдэж байна.

2021 оны 12 сарын 31 болон 2020 оны 12 сарын 31-нээрх өр төлбөрийг төлөгдөх хугацаагаар ангилбал дараах байдалтай байна.

	Төлөгдөхөөр хүлээгдэж байгаа /мян.төг/	1 жилээс дээш 5 жилийн дотор төлөгдөх /мян.төг/	Нийт /мян.төг/
2021 оны 12 сарын 31-нээр:			
Байгууллагад өгөх өглөг	24,070.1		24,070.1
Татвар, НДШ-ийн өглөг	45,434.9		45,434.9
Богино хугацаат зээл	51,247.5		51,247.5
Банкны зээл		406,214.0	406,214.0
Урьдчилж орсон орлого	22,486.5		22,486.5
Бусад	434.0		434.0
	143,673.0	406,214.0	549,887.0

	Төлөгдөхөөр хүлээгдэж байгаа /мян.төг/	1 жилээс дээш 5 жилийн дотор төлөгдөх /мян.төг/	Нийт /мян.төг/
2020 оны 12 сарын 31-нээр:			
Байгууллагад өгөх өглөг	17,431.5		17,431.5
Татварын өглөг	65,725.4		65,725.4
Хувь хүнээс авсан зээл	91,621.4		91,621.4
Банкны зээл	397,804.5	47,450.5	445,255.0
Урьдчилж орсон орлого	6,985.0		6,985.0
Бусад	122.3		122.3
	579,688.1	47,450.5	627,138.6

АНД-ЭНЕРГИ ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

30. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ ЧУХАЛ АСУУДЛУУД

АНД-ЭНЕРГИ ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд 21-УВ/03/77-9 тоот Аудиторын зөвлөмжийг хүргүүлсэн болно. Уг зөвлөмжийн залруулагдаагүй алдааны хэрэгжилт болон уламжлалт эрсдэлийг авч үзэх шаардлагатай.

31. ХҮЛЭЭЖ БОЛЗОШГҮЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бизнесийн хэвийн явцад компани нь түүний эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Компанийн удирдлага эдгээр нэхэмжлэлүүдээс үүдэлтэйгээр ирээдүйд материаллаг алдагдалд орж болзошгүй тул шаардлагатай сэргийлэх арга хэмжээг авах нь зүйтэй юм.

а. Татвар, НДШ, шүүхийн зарга маргаан

Монгол улсын татвар, Нийгмийн даатгал, бусад хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, зарим заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байх тохиолдол байдаг. Мөн түүнчлэн төрийн байгууллагууд хууль тогтоомжийг тайлбарлан үнэлэхдээ хатуу байр суурь баримталдаг ба өмнө нь маргалдаж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг үгүйсгэх боломжтой. Үүний үр дүнд, мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Хэдийгээр Компанийн удирдлага бусдын өмнө хүлээсэн болзошгүй үүрэг хариуцлага болон алдагдал учрах үйл явдал тохиолдоогүй гэж үзэж болох боловч (татвар, нийгмийн даатгал, шүүх гэх мэт) төрийн байгууллагын байр суурийг урьдчилан таамаглах боломжгүй юм.

б. Татвар, НДШ, хураамжтай холбоотой болзошгүй өр төлбөр

Компанийн хувьд төлөхөөр хүлээгдэж буй татварын хуримтлагдсан өр төлбөрүүд нь 2021 оны 12 сарын 31-ээр дараах байдалтай байна. Үүнд: НДШ-ийн өглөг 26,249.4 мянган төгрөг, НӨАТ-ийн өглөг 10,994.4 мянган төгрөг, ААНОАТ-ын өглөг 988.5 мянган төгрөг, Суутган ба ХХОАТ-ын өглөг 7,202.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба уг өглөгийг хугацаанд нь төлөөгүйгээс хамаарч ирээдүйд алданги хүлээх эрсдэлтэй байна.

в. Шүүхийн нэхэмжлэл

Өнгөрсөн үйл явдлын үр дүнгээс хамааран компани нь хууль ёсны эсвэл практик үүрэг хариуцлагыг хүлээж байгаа бөгөөд энэ хариуцлагыг зохих ёсоор тодорхойлох боломжтой ба эдийн засгийн үр өгөөжөөр уг хариуцлагыг барагдуулах боломжтой үед болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

32. САНХҮҮГИЙН ТАЙЛАНТ ХУГАЦААН ДАХЬ ОНЦЛОГ АСУУДАЛ


Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 3 сарын 12-ны өдөр COVID-19 вирусийн тархалтыг дэлхийн цар тахал гэж зарласан. Монгол Улсын Засгийн газар вирусийн тархалтыг зогсоох арга хэмжээ, тухайлбал олон нийтийн үйл ажиллагааг хориглох, хоорондын зай барих, хил хаах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн. COVID-19 түүний нийгэм эдийн засагт учруулах нөлөөллийг багасгах зорилгоор аж ахуйн нэгжүүдэд татварын болон НДШ-ийн хөнгөлөлт чөлөөлөлтийг 2021 оны 1 сарын 1-ээс 2021 оны 7 сарын 1 хүртэл үргэлжлүүлэхээр холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

33. ТАЙЛАГНАЛЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД

Санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал гараагүй.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН КОМПАНИ

Since 2007



МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, UB Tower, 15-р давхар, 1502 тоот

Утас: 7013-1044

Цахим хуудас: www.magicgroup.mn

Э-шуудан: audit@magicgroup.mn